

Шилийн Богдын байгалийн дурсгалт газар

Хамгаалалтад авсан үндэслэл



Photo courtesy of B.Munkhchuluun



Photo courtesy of B.Munkhchuluun



Photo courtesy of B.Munkhchuluun

Дундад Халхын тэгш өндөрлөг, Дарьгангын тэгш өндөрлөгийн мужид 200 орчим гаот уул байгаагийн дотор хамгийн өндөр нь 1778 м өндөр Шилийн богд уул юм. Дарьгангын нутагт 60 шахам хүн чулуун хөшөө бий. Энэхүү өвөрмөц сонин байгаль эхийн бүтээлийн хамгаалах зорилгоор УИХ-ын 2004 оны 6 дугаар тогтоолоор байгалийн дурсгалт газар болгон улсын тусгай хамгаалалтад авчээ.

Хамгаалалтын үйл ажиллагааг Дарьгангын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хариуцдаг ба хамгаалалтын захиргаа Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвд байрладаг ба **Дарьгангын БЦГ-ын** зэрэгцээгээр **Лхачинвандад уул БНГ, Шилийн богд ДГ, Хөргийн хөндийн ДГ-ын** хамгаалалтын үйл ажиллагааг давхар хариуцан ажилладаг.

Газарзүйн онцлог

Гарал үүслийн хувьд гэлт уулын ангид эртхий галт уулын бэгэлцэгт багтана. Уулсын хоорондох хөндий, талаар хүрмэн чулуун лав тогтсон тул тэдгээрийн гадарга нилээд чулуурхаг юм.

Энэ нутагт тогтмол урсгалтай гол, горхи ховор тул борооны усны эвдлэх үйл ажиллагаа голлоно. Аадар бороо, гуу жалга үүсгэн янз бүрийн хушуурсан тунадас үүсгэдэг байна. Жилдээ 200-250 мм тунадас унах ба Дарьгангын тэгш өндөрлөг, Эрдэнэцагааны орчмоор 250-300

мм хүрч нэмэгдэх онцлогтой байна. Өвөл цасан бүрхэвчийн зузаан 20 мм хүрдэг. Жилийн дундаж салхийны хурд 6-8 м/с, баруун, баруун хойд зүгийн салхи зонхилно. Салхины хамгийн их хурд 40м/с хүрэх үе тохиолдоно.

Агаарын жилийн дундаж температур 0°C орчим, 1-сарын дундаж температур -20°C хэм, зуны 7-р сарын дундаж +20°C хэм, харин үнэмлэхүй хүйтэн нь -40°C, үнэмлэхүй халуун нь +39,0°C хэм хүрч температурын агууриг дагуу 79,1°C болно.

Дарьгангын тэгш өндөрлөг нутагт хар хүрэн, хүрэн ба бараан хөрс зонхилдог хэдий ч урд захаар хөрс цайвар хүрэн болж ирнэ. Хөрсөн бүрхэвч ихэнхдээ хүрэн, цайвар хүрэн хөрснөөс бүрэлдэнэ. Шилийн богд уулын орчмоор хар хүрэн хөрс үзэгдэнэ.

Ургамлын аймаг

Шилийн Богд уул нь ургамал-газарзүйн мужлалаар Езразийн хээрмйн мужийн, Дорнод Монголын хээрийн тойрогт хамаарна. Шилийн Богд орчимд 28 овгийн 75 төрөл 108 зүйлийн ургамал бүртгэгджээ. Шилийн Богд уулын ургамалжилт нь ойт хээр, хээр, говийн бүсийг төлөөлж чадах нэн ховор, ховор ургамал 30 гаруй зүйл,

эмийн болон хүнсний 20 гаруй зүйл, мөн балт болон тэжээлийн шимт чанар сайтай ургамал их ургадаг, зүйлийн бүрэлдхүүнээр баялаг.

Амьтны аймаг

Амьтны аймагт туурайтан, мэрэгчид хоёр гол суурийг эзэлнэ. Эдгээрийн дотор цагаан зээр, тарвага зэрэг ангийн ихээхэн ач холбогдолтой амьтдын зэрэгцээ бэлчээрт хортой үлийн цагаан зэрэг мэрэгчид байдаг. Мөн чоно, үнэг цөөнгүй байна.

Эх сурвалж:

1. Оюунгэрэл.Б. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг.УБ.2004
2. Мягмарсүрэн.Д, Энэбиш.Д, Монгол улсын дархалсан газар нутгууд. 2007.УБ

Мэдээллийг бэлтгэсэн: МУИС Экологи-2 Э.Өгөөмөр

Харилцах хаяг : Сүхбаатар аймаг, Дарьганга сум. Дарьгангын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа

*Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн
Монгол дахь хөтөлбөрийн газар*

Web site: www.wwf.mn www.econet.mn
E-mail: info@wwf.mn

2009.03.12